



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ОРХОН АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ЭМХЭТГЭЛ

/жинхэнэ гүйцэтгэлээр/

2017

I	Танилцуулга	2
----------	--------------------	---

II	Нийгмийн үзүүлэлт	
1	Хүн ам	18
2	Ажиллах хүч	31
3	Хүн амын амьжиргаа	38
4	Нийгмийн даатгал, халамж	40
5	Боловсрол	45
6	Эрүүл мэнд	54
7	Соёл урлаг, биеийн тамир, спорт	58
8	Байгаль орчин	60
9	Гэмт хэрэг	63

III	Эдийн засгийн үзүүлэлт	
10	Үндэсний тооцоо	66
11	Мөнгө, банк	67
12	Төсвийн орлого, зарлага	72
13	Гадаад худалдаа	74
14	Үнэ	75
15	Хөдөө аж ахуй	79
16	Аж үйлдвэр	109
17	Тээвэр, харилцаа холбоо	119
18	Худалдаа, үйлчилгээ	122
19	Барилга, орон сууц, нийтийн аж ахуй	125
20	Бизнес регистр	133

I ТАНИЛЦУУЛГА





Хүн ам

Хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн санд 28.7 мянган өрхөд манай аймгийн харъяат 103.6 мянган хүн бүртгэлтэй байгаагаас 1.9 хувь нь гадаадад зургаа ба түүнээс дээш сарын хугацаагаар оршин суудаг, 6.2 хувь нь хаягандаа амьдардаггүй, 91.9 хувь буюу 95.2 мянган хүн нь байнгын оршин суугч байна.

Манай аймагт 16 орны 588 гадаад иргэд ажиллаж амьдарч байна.

Аймгийн суурин хүн амын тоо 101652-т хүрч, хүйсийн харьцаа 96.3 байна. Суурин хүн амын 63.4 хувь нь залуу болон идэр насныхан, 30.3 хувь нь хүүхдүүд, 6.3 хувь нь хөгшид байна. 90-ээс дээш насны 75 өндөр настан байгаагаас 97 настай 5, 98 настай 1, 102 настай 1 хүн байгаа нь Баян-Өндөр сумын иргэд байна.

Аймгийн нийт өрхийн 95.9 хувь, суурин хүн амын 96.2 хувь нь Баян-Өндөр суманд оршин сууж байна. Багуудаас хамгийн их хүн амтай нь Цагаанчулуут, Согоот, Хүрэнбулаг, Оюут, Баянцагаан, Дэнж, Уурхайчин, Яргуйт, Эрдэнэ баг бөгөөд эдгээрт 5.0-7.1 мянган хүн оршин сууж байгаа нь Баян-Өндөр сумын нийт хүн амын 52.0 хувийг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 125 бүтэн өнчин, 1009 хагас өнчин хүүхэд, 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх 1619, өрх толгойлсон эмэгтэйчүүд 3021 байна. Өмнөх оноос хагас өнчин хүүхдийн тоо 3.0 хувиар, бүтэн өнчин хүүхэд 7.4 хувиар буурчээ.

Хүн амын ердийн хөдөлгөөн

Тайлант онд төрсөн 2388 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн, нас барсан 537 хүнийг иргэний бүртгэлээс хасч, 652 гэрлэлт бүртгэгдэн, 161 гэрлэлт цуцлагдаж, 66 хүүхэд үрчлэгдсэн байна. Өмнөх оноос төрөлт 1.8 хувиар, нас баралт 2.5 хувиар, гэрлэлт 15.8 хувиар, үрчлэлт 34.7 хувиар нэмэгдэж, гэр бүл цуцлалт 9.0 хувиар буурчээ.

Бүртгүүлсэн гэр бүлийн 31.1 хувь тайлант онд гэр бүл болжээ. Гэрлэсэн эрэгтэйчүүдийн 43.1 хувь нь 25-29 насныхан, 20.6 хувь нь 20-24 насныхан, эмэгтэйчүүдийн 40.8 хувь нь 25-29 насныхан, 28.1 хувь нь 20-24 насныхан байна.

Нийт гэр бүл цуцлалтын 33.5 хувь 10-14 жил гэр бүл байсан, үрчлэгдсэн хүүхдүүдийн 47.0 хувь нь 3 хүртэл насныхан байна.

Тайлант онд аймгийн дүнгээр 1000 хүнд ногдох төрөлт 23.0, нас баралт 5.2 промил болж, өмнөх оны түвшинд байж, нас баралт 0.1 промилээр нэмэгджээ. 1000 өрхөд ногдох гэрлэлт 2.7 промилээр нэмэгдэж, цуцлалт 0.7 промилээр буурсан үзүүлэлттэй байна.

Хүн амын шилжилт хөдөлгөөн

УБХ-ийн мэдээгээр тайлант жилд 1944 хүн шилжин явж, 2359 хүн шилжин иржээ. Шилжин ирэгсдийн 36.6 хувь нь Улаанбаатар хотоос, 22.6 хувь нь Булган аймгаас, 4.9 хувь нь Хөвсгөл аймгаас шилжин ирсэн нь дийлэнх хувийг эзэлж байна. Насны хувьд шилжин ирэгсдийн 63.6 хувь нь 15-54 насныхан байна. Шилжин явагсдын 31.4 хувь нь Улаанбаатар хот руу шилжин явжээ. Шилжих хөдөлгөөн 1х1.2 харьцаатай байна.



Ажил эрхлэлт

Ажиллах хүчний түүвэр судалгааны үр дүнгээр тус аймагт эдийн засгийн идэвхтэй 42.1 мянган хүн байгаагийн 76.5 хувь буюу 32.2 мянга нь ажиллагсад, 23.5 хувь буюу 9.9 мянган хүн нь ажил идэвхтэй эрж хайж байгаа хүмүүс байна. Өмнөх оноос ажиллагсдын тоо 2.7 хувиар буурч, ажил эрж хайж байгаа иргэдийн тоо 3.1 хувиар, ажилгүйдлийн түвшин 1.1 пунктээр нэмэгджээ.

Жилийн эцсийн байдлаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 1229 хүн бүртгэлтэй байгаагийн 57.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өмнөх оноос 27.1 хувиар буюу 456 хүнээр багасчээ.

Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 14.9 хувь нь 16-24 насныхан, 20.3 хувь нь 45-60 насныхан, 23.0 хувь нь 35-44 насныхан, 41.7 хувь нь 25-34 насныхан байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 49.7 хувийг бүрэн дунд, 31.2 хувийг дээд, 8.1 хувийг мэргэжлийн анхан шатны, 4.8 хувийг суурь, 4.6 хувийг тусгай дунд, 0.7 хувийг бага боловсролтой, 1.0 хувийг боловсролгүй хүмүүс эзэлж байна.

Жилийн туршид бүртгэгдсэн ажилгүйчүүдийн 22.5 хувь нь сургууль төгсөгчид, 10.4 хувь нь орон тооны цомхотголд орсон, 9.2 хувь нь өөр газраас шилжин ирэгсэд байна.

Тайлант онд нийт 2163 ажлын байр бий болсны 993 буюу 45.9 хувь нь шинээр бий болжээ. Сүүлийн 2 жилд 2225 түр болон байнгын ажлын байр шинээр бий болсон байна.

Ажлын байраар хангагдагсдын 654 буюу 30.2 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 334 буюу 15.4 хувь нь худалдааны салбарт ажиллаж байна. Шинээр бий болсон ажлын байрны 36.8 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 24.8 хувь нь худалдааны салбарт, 9.9 хувь нь боловсролын салбарт бий болжээ.



Нийгмийн халамж, даатгал

Аймгийн дүнгээр давхардсан тоогоор 57.0 мянган хүнд 72.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт олгосноос 1.9 мянган хүнд 2.6 тэрбум төгрөгийн халамжийн тэтгэвэр, 2.2 мянган хүнд 1.2 тэрбум төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмж,

нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 2.1 мянган хүнд 938.8 сая төгрөгийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж, 7.8 мянган ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 950.2 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлт, хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн улсын төсвийн санхүүжилтээр 24.0 мянган хүнд 3.4 тэрбум төгрөгийн тэтгэмж, хөнгөлөлт олгожээ. Өмнөх оноос хамрагдсан хүн 14.9 хувиар, олгосон халамжийн хэмжээ 0.7 хувиар нэмэгдсэн байна.

Орон нутгаас 70-аас дээш насны 2.7 мянган ахмад настанд 32.5 сая төгрөгийн сар шинийн хүндэтгэл, ахмадын 3 Төрийн бус байгууллага, зуны саам сувилалд 265 иргэнд 37.6 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлж, орон нутгийн халамжийн сангаас үзүүлсэн нийгмийн халамжийн үйлчилгээ өмнөх оноос 50.7 хувиар өссөн байна.

Нийгмийн даатгалын сангийн орлогод 91.4 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 35.7 хувиар давж биелсэн байна. ҮОМШӨ сангийн орлогын төлөвлөгөө 31.6 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 13.8 хувиар тасарч бусад сангийн орлогын төлөвлөгөө 26.7% – 97.3% давж биелсэний дотор ажилгүйдлийн сангийн орлого 97.3 хувиар давж биелжээ. Сангийн нийт орлого өмнөх оноос 44.9 хувиар их байна.

Тайлант хугацаанд 1422 хүнд шинээр тэтгэвэр тогтоосноос 64.4 хувьд нь өндөр насны, 29.7 хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 5.9 хувьд нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоожээ. Тэтгэвэр тогтоолгосон хүний тоо өмнөх оноос 1.8 хувиар их байна.

Эрүүл мэндийн даатгалд даатгуулагч 100.0 мянган хүний 55.1 хувь нь төр төлбөрийг нь даадаг, 44.9 хувь нь заавал даатгуулагсад байна. Өмнөх оноос эрүүл мэндийн даатгалд даатгуулагч 1.8 хувиар өсч, тэтгэврийн нэрийн данс нээлгэсэн хүний тоо 0.2 хувиар нэмэгджээ.



Боловсрол

Боловсрол, соёл урлагийн газрын мэдээгээр 2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 24 сургуулийн 654 бүлэгт 19.1 мянган хүүхэд суралцаж, сургуулийн өмнөх боловсролын 37 байгууллагын 272 бүлэгт 8.7 мянган хүүхэд хамрагдаж, эдгээрт 1385 багш сурган хүмүүжүүлэгч ажиллаж байна. Өмнөх хичээлийн жилээс багш сурган хүмүүжүүлэгч 3.6 хувиар, суралцагсад 2.7 хувиар, СӨБ-д хамрагдаж байгаа хүүхэд 6.9 хувиар, хамралтын хувь 5.7 пунктээр нэмэгджээ.

Нийт багш нарын 73.5 хувь нь ерөнхий боловсролын дунд сургуульд, 26.5 хувь нь сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн нэг сургуульд ногдох суралцагч, багшийн тоо 5.8-7.4 хувиар буурч, нэг багшид ногдох суралцагчид, анги дүүргэлт өмнөх оноос 1.7-1.8 хувиар нэмэгдсэн байна. Цэцэрлэгийн нэг бүлэгт ногдох хүүхэд, нэг цэцэрлэгт ногдох хүүхдийн тоо 1.4-4.0 хувиар нэмэгджээ.

2016-2017 оны хичээлийн жилд 2.6 мянган хүүхэд 9, 12-р ангийг төгссөнөөс 46.7 хувь нь суурь боловсролыг, 53.3 хувь нь бүрэн дунд боловсролыг эзэмшжээ. Өмнөх оноос I-р ангид элсэгч 8.8 хувиар, X-р ангид элсэн суралцагч 50.1 хувиар их байна.

3 их, дээд сургуульд 1.4 мянган оюутан суралцаж байгаагийн 69.8 хувь нь их сургуульд сурч байна. Эдгээр их дээд сургуульд 123 үндсэн багш сургалт явуулж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын стандарт хангалт 99.6, чанар 79.9 хувь байна. Өмнөх хичээлийн жилээс стандарт хангалт 5.7 пунктээр, чанар 0. пунктээр өсчээ.

Сумдын ЗДТГ-ын мэдээгээр сургууль завсардсан 18 хүүхэд байгаагийн ихэнх нь Баянцагаан, Даваат, Наран, Говил, Оюут, Жаргалант багуудад байна.



Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн 77 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 8 нь өрхийн эрүүл мэндийн төв, 64 нь хувийн эмнэлэг байна. Эдгээрт 325 их эмч, 679 дунд мэргэжилтэн ажиллаж байна. Хувийн хэвшлийн 12 эмнэлэг 200 ортойгоор ажиллаж байгаа нь нийт орны 30.8 хувийг эзэлж байна.

Аймгийн 10000 хүнд 32 их эмч, 67 дунд мэргэжилтэн, 64 ор, нэг их эмчид 314 хүн ногдож байна.

Эрүүл мэндийн байгууллагууд 593.1 мянган хүнд үзлэг хийснээс 37.0 хувийг нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна. Өмнөх оноос нийт үзлэг 4.4 хувиар, урьдчилан сэргийлэх үзлэгийн нийт үзлэгт эзлэх хувийн жин 2.4 пунктээр буурчээ.

Жилийн дүнгээр 1 хүн дунджаар 6 удаа эмнэлэгт үзүүлсэн ба дунджаар 7 хоног эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна.

Сэргийлэх тарилгад 15.0 мянган хүн хамрагдсан нь нийт хамрагдвал зохих хүний 98.0 хувь нь бөгөөд өмнөх оноос хамралт 0.4 пунктээр доогуур байна.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд давхардсан тоогоор 99.8 мянган хүнд үйлчилсэн нь өмнөх оноос 21.4 хувиар багасчээ.

Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2566 эх амаржин, 493 хүн нас баржээ. Нас баралтын 2.6 хувийг нялхсын нас баралт эзэлж байна. 1000 хүнд ногдох төрөлт 1.2 промилээр, нас баралт 0.1 промилээр, 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 7.6 промилээр буурчээ. Тайлант хугацаанд эхийн эндэгдэл гараагүй байна.

Халдварт өвчнөөр өвчилсөн 736 тохиолдол гарсан нь өмнөх оноос 48.9 хувиар буюу 69.2 продицимилээр буурсан байна. Нийт өвчлөлтийн 20.5 хувийг тэмбүү, 14.4

хувийг трихоманаз, 12.6 хувийг салхинцэцэг, 11.5 хувийг сүрьеэ, 11.5 хувийг мөөгөнцөр, 6.7 хувийг суулгалт халдвар, 5.6 хувийг цусан суулга, 2.6 хувийг гар, хөл, амны өвчин, 2.0 хувийг халдварт шар, 0.4 хувийг хоолны хордлого эзэлж байна. Нийт өвчлөлийн 41.8 хувь нь бэлгийн замын халдварт өвчин, үүний 49.0 хувь нь тэмбүүгээр, 34.4 хувь нь трихоманаз, 16.6 хувь нь заг хүйтнээр өвчлөгсөд байна.

Өмнөх оноос 10000 хүнд ногдох бруцеллез 0.6, сүрьеэ 0.8, тэмбүү 4.4, мөөгөнцөр 0.7, гар, хөл, амны өвчин 5.4 продицимилээр буурч, хачигт риккеттиоз, улаан эсэргэнэ, хачигт боррелиоз мөн үеийн түвшинд байж, бусад халдварт өвчний гаралт 0.1-4.6 продицимилээр нэмэгдсэнээс суулгалт халдвар 4.6 продицимилээр нэмэгджээ.

Өмнөх онд гарч байгаагүй хамуугаар өвчилсөн 4, бүслүүр үлдээр 16 тохиолдол гарсан бол харин өмнөх онд гарч байсан эмнэлгийн дотоод халдвар, сальмонеллэз, улаан бурхан, улаан эсэргэнэ, денге чичрэгээр өвчилсөн тохиолдол гараагүй байна.



Соёл урлаг, биеийн тамир

Номын төв 32.0 мянган ширхэг сан хөмрөгийн номтой ба 7.8 мянган хүнд уншигчийн карт нээн өгч, 63.7 мянган хүнд 137.6 мянган ширхэг ном, хэвлэл олгон үйлчилжээ. Карттай уншигчийн 81.9 хувь нь, үйлчлүүлэгсдийн 75.9 хувь нь сургуулийн сурагчид байна. 1.0 сая төгрөгийн ном, соёлын бараа худалдаалжээ.

Соёл урлагийн байгууллагууд 222 удаа тоглолт хийн, 44.4 мянган хүнд тоглолт, үзмэрээ толилуулан, 996 удаагийн ажил зохион байгуулан 164.0 мянган хүнийг хамруулж, 31.7 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Өмнөх оноос тоглолт 14.4 хувиар, үзэгчдийн тоо 1.4 хувиар, зохиогдсон ажил 34.2 хувиар, хамрагдсан хүний тоо 12.9 хувиар өссөн байна.

Манай аймгийн баг, тамирчид спортын уралдаан, тэмцээнээс 666 медаль хүртсэний 32.0 хувь нь алт, 31.5 хувь нь мөнгө, 36.5 хувь нь хүрэл медаль байна. Үүнээс дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс 8 алт, 6 мөнгө, 6 хүрэл; ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс 9 алт, 5 мөнгө, 6 хүрэл; олон улсын тэмцээнээс 7 алт, 8 мөнгө, 13 хүрэл медаль хүртжээ.

Спортын болон биеийн тамирын чийрэгжүүлэлтийн 41 төрлийн секцэнд 23.7 мянган хүн хичээллэсний 49.8 хувь нь насанд хүрэгчид, 50.2 хувь нь өсвөр үеийнхэн байна.



Байгаль орчин

Байгаль цаг агаарын хувьд сарын дундаж температур -12.9 хэмийн хүйтэн байж, өмнөх оноос 1.1 хэмээр хүйтэн байна. Хур тунадас өмнөх оноос 3.4 мм-ээр их байна.

Тайлант хугацаанд нийт 14 га талбайд ойжуулалтын ажил гүйцэтгэсэн нь өмнөх оноос 40.0 хувиар их байна. Энэ онд шилмүүст мод 28.0 мянган ширхэг, навчит мод 17.0 мянган ширхэг, бут сөөг 25.0 мянган ширхэг тарьж, тарьсан модны тоо 8.0 хувиар өсчээ. Бүх нийтээр мод тарих ажил идэвхитэй явагдах болсоноор навчит болон бут сөөгний тарилт өссөн байна.



Сахилга дэг журам

Цагдаагийн газрын мэдээгээр 881 хэрэгт 676 хүн холбогдон шалгагдаж, хэргийн илрүүлэлт 43.9 хувьтай байна. Өмнөх оноос бүртгэгдсэн хэрэг 66.9 хувиар, холбогдогч 25.4 хувиар, 18–аас дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг 48.5 продицимилээр нэмэгдэж, хэргийн илрүүлэлт 26.4 пунктээр буурчээ.

Нийт бүртгэгдсэн хэргийн 59.5 хувь нь бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг, 27.5 хувь нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг, 20.9 хувь нь хүнд, онц хүнд хэрэг байгаа ба өмнөх оноос согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 17.5 хувиар, бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг 2.8 дахин, хүнд, онц хүнд хэрэг 3.8 дахин нэмэгдсэн байна.

Бүртгэгдсэн хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл нийт хэргийн 34.5 хувийг хулгайн хэрэг, 32.2 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг, 12.4 хувийг залилан мэхлэх, завшиж үрэгдүүлэх хэрэг, 4.4 хувийг хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг хэрэг, 3.5 хувийг дээрмийн хэрэг, 2.5 хувийг хүчингийн хэрэг, 1.2 хувийг танхай, 0.8 хувийг орчиндоо аюул учруулах амьтныг хамгаалалтгүй байлгах хэрэг, 0.5 хувийг албан тушаалын хэрэг, 0.2 хувийг хүн амины хэрэг, 0.1 хувийг булаах хэрэг эзэлж байна.

Өмнөх оноос танхайрах, бусдын эд хөрөнгө булаах, хүнийг санаатай алах хэргийн гаралт 8.3-71.4 хувиар багасч, орчиндоо аюул учруулах амьтныг хамгаалалтгүй байлгах хэрэг мөн үеийн түвшинд байж, бусад хэргийн гаралт 30.0%-4.5 дахин нэмэгдсэний дотор залилан мэхлэх, завшиж үрэгдүүлэх хэрэг 4.5 дахин буюу 85-аар нэмэгджээ.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 1.5 тэрбум төгрөгийн хохирол учирч, 19 хүн нас барж, 378 хүн хүнд ба хөнгөнөөр гэмтжээ. Нийт хохирлын 39.7 хувийг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт холбогдсон 676 хүний 60.8 хувь нь эрхэлсэн ажил хөдөлмөргүй, 43.5 хувь нь согтуугаар, 21.7 хувь нь бүлэглэн гэмт хэрэг үйлдсэн ба 10.1 хувь нь 18 хүртэл насны хүүхэд байна.

68 холбогдогчтой, 28.3 сая төгрөгийн хохирлын хэмжээтэй хүүхдийн 60 гэмт хэрэг гарсан ба гэмт хэргийн тоо өмнөх оноос 2.2 дахин өсч, холбогдогч 78.9 хувиар, учруулсан хохирлын хэмжээ 59.9 хувиар нэмэгджээ.

Хэв журмын нөхцөл байдлын хувьд 5.4 мянган хүн эрүүлжигдэн, 700 хүн захиргааны шийтгэлээр баривчлагдсан байна. Өмнөх оноос баривчлагдсан хүний тоо 85.2 хувиар, эрүүлжүүлэгдсэн хүний тоо 10.6 хувиар нэмэгджээ.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцож байсан 1634 жолоочийг илрүүлэн, 1319 жолоочийн эрхийг тодорхой хугацаагаар хасч шийтгэжээ. Өмнөх оноос согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон жолоочийн тоо 7.7 хувиар, эрх хасалт 8.4 хувиар нэмэгдсэн байна.

Шүүхээр 1962 хэрэг шийдвэрлэсний 2.2 хувийг захиргааны, 21.7 хувийг эрүүгийн, 76.1 хувийг иргэний хэрэг эзэлж байгаа ба өмнөх оноос нийт шийдвэрлэсэн хэрэг 1.3 хувиар, иргэний хэрэг 15.4 хувиар буурч, эрүүгийн хэрэг 2.2 дахин, захиргааны хэрэг 59.3 хувиар нэмэгджээ.



Банк, мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр 1.5 их наяд төгрөгийг гүйлгээнээс татаж, 1.5 их наяд төгрөгийг гүйлгээнд гаргасан байна. Өмнөх оноос гүйлгээнээс татсан төгрөгийн хэмжээ 1.3 хувиар, гүйлгээнд гаргасан төгрөгийн хэмжээ 1.3 хувиар өссөн байна.

Иргэдийн хувийн мөнгөн хадгаламж 205.7 тэрбум төгрөг болж, аймгийн нэг хүнд дунджаар 2018375 төгрөгийн, нэг хадгаламж эзэмшигчид 1866309 төгрөгийн хадгаламж ногдож байна. Өмнөх оноос хадгаламжийн үлдэгдэл 13.9 хувиар нэмэгдэж, хадгаламж эзэмшигчийн тоо 0.2 хувиар буурчээ.

Банкуудын төгрөгийн хугацаагүй хадгаламжийн сарын хүү 0.48-0.6 хувь, хугацаатай хадгаламжийн сарын хүү 0.7-1.4 хувь, харин хугацааны эцэст зарласан зээлийн сарын хүү 0.42-2.6 хувьтай байна.

Арилжааны банкуудын дүнгээр 237.5 тэрбум төгрөгийн зээлийг 64.0 мянган иргэд, аж ахуйн нэгжид олгожээ. Өмнөх оноос зээлжигчийн тоо 0.4 хувиар буурч, олгосон зээлийн хэмжээ 19.2 хувиар өссөн байна.

Банк бус санхүүгийн 2 байгууллага, 10 хадгаламж зээлийн хоршоод 514 хадгаламж эзэмшигчийн 2.7 тэрбум төгрөгийн хадгаламжийг төвлөрүүлж, 3014 иргэд, аж ахуйн нэгжид 10.3 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Өмнөх оноос олгосон зээлийн хэмжээ 87.6 хувиар, хадгаламж 6.3 хувиар, зээлжигчийн тоо 21.3 хувиар өсчээ.



Төсвийн орлого, зарлага

Аймгийн төсөвт 85.8 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 104.7 хувьтай байна. Татварын орлогын төлөвлөгөө 5.8 хувиар, татварын бус орлогын төлөвлөгөө 3.6 хувиар давж биелсэн байна. Нийт орлогын 54.4 хувь нь татварын, 45.6 хувь нь татварын бус орлого байна. Өмнөх оноос нийт орлого 3.7 хувиар нэмэгджээ.

Орон нутгийн төсвөөс төлөвлөгөөт санхүүжилтийн 95.9 хувь буюу 89.1 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийсний 3.2 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 18.2 хувийг бараа үйлчилгээний зардалд, 20.2 хувийг хөрөнгийн зардалд, 28.6 хувийг цалин хөлсөнд, 29.8 хувийг татаас ба урсгал шилжүүлэгт зарцуулжээ.

Салбарын хувьд эдийн засгийн бусад салбарт 0.5 хувийг, эрүүл мэнд, спортын салбарт 1.8 хувийг, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн салбарт 9.1 хувийг, ангилагдаагүй бусад зардалд 20.2 хувийг нийтийн ерөнхий үйлчилгээнд 33.0 хувийг, боловсрол соёл урлагийн салбарт 35.3 хувийг зарцуулсан байна. Өмнөх оноос нийт зарлага санхүүжилт 5.8 хувиар бага байна.

Аймгийн хэмжээнд 1822.2 тэрбум төгрөгийн нэмэгдэл өртөг бий болж өмнөх оноос 64.2 хувь буюу 712.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хангайн бүсийн хэмжээнд амьжиргааны доод түвшин 2017 онд 173500 төгрөг болж 2016 оноос 1.6 хувь буюу 2.7 мянган төгрөгөөр нэмэгджээ.



Гадаад худалдаа

Аймгийн хэмжээнд гадаад худалдаагаар 2.3 их наяд төгрөг буюу 949.5 сая ам долларын бараа эргэлт хийсэн байна. Өмнөх оноос нийт эргэлт 40.9 хувиар өссөнөөс экспорт 47.6 хувиар, импорт 1.6 хувиар өссөн байна.

Гадаад худалдаагаар гол нэрийн бүтээгдэхүүнээс 651.8 мян.тн зэсийн баяжмал, 6.5 мян.тн молибдены баяжмал, 15.6 мян.тн катодын зэс, 29.8 мян.м2 хивс зэрэг 2.1 их наяд төгрөгийн бараа бүтээгдэхүүн экспортлож, дизелийн түлш 28.6 мян.тн, бензин 22.3 мян.тн, тээрмийн ган бөмбөлөг 9.6 мян.тн зэрэг нийт дүнгээр 240.9 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн импортоор авчээ.

Өмнөх оноос экспортолсон зэсийн баяжмал 0.2 хувиар, молибдений баяжмал 14.0 хувиар нэмэгдэж, экспортолсон хөлдүү мах 0.7 хувиар, катодын зэс 4.9 хувиар, хивс 51.4 хувиар, импортолсон тээрмийн ган бөмбөлөг 2.2 хувиар, дизелийн түлш 5.5 хувиар, бензин 15.9 хувиар багассан байна.



Үнэ

Хэрэглээний үнэ тарифын судалгааг хэрэглээний сагс дахь 238 нэр төрлийн бараа үйлчилгээнд хийв. Судалгааны дүнгээр үнийн ерөнхий индекс энэ сард 101.0 хувьтай байна. Индекс 2015 оноос 6.1 хувиар, өмнөх оноос 5.6 хувиар өссөн байна.

Өмнөх сараас амралт чөлөөт цаг, соёлын бараа, согтууруулах ундаа, тамхи, эм тариа эмнэлгийн үйлчилгээ, бусад бараа үйлчилгээний бүлэг, хүнсний бараа, гэр ахуйн барааны бүлгийн индекс 0.4-5.5 хувиар өсч, бусад барааны бүлгийн индекс өмнөх сарын түвшинд байна.

Хүнсний бараа, ундаа усны бүлгийн индексийн өсөлтөнд сүү, тарагны 1 литрийн үнэ 300-500 төгрөгөөр, манжин, байцаа, төмс 100-200 төгрөгөөр өссөн нь, гэр ахуйн цахилгаан барааны бүлгийн үнийн өсөлтөнд гар хийцийн модон тавилгын үнэ 20000-30000 төгрөгөөр, хагас автомат угаалгын машины үнэ 43300 төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.



Хөдөө аж ахуй

Жилийн эцсийн мал тэжээвэр амьтдын тооллогоор 881 малчин өрхөд 122.3 мянган мал тоологдов. Өмнөх жилийнхээс малын тоо 8.8 хувиар буурч, малчин өрх 70, малтай өрх 87 өрхөөр нэмэгдсэн байна.

Нийт малчдын 66.0 хувь нь 35-60 насны, 19.3 хувь нь 16-34 насны, 14.7 хувь нь тэтгэврийн насны малчид ба эдгээрийн 43.5 хувь нь эмэгтэйчүүд байна.

Бэлэн малын 95.7 хувь нь иргэдийн хувийн, бусад нь албан газрын мал бөгөөд нийт малын 39.0 хувийг хонь, 33.1 хувийг ямаа, 17.9 хувийг үхэр, 10.0 хувийг адуу эзэлж, нийт малын 27.9 хувь нь бод мал байна. Тэмээн сүрэг 1 толгойгоор нэмэгдсэн байна.

Аймгийн 10 аж ахуйн нэгж байгууллагад 5.3 мянган толгой мал тоологджээ.

Өмнөх оноос Баян-Өндөр сумын мал 1.4 хувиар өсч, Жаргалант сумынх 15.4 хувиар буурсан ба нийт малын 56.5 хувь нь Жаргалант суманд байна.

Нийт малтай өрхийн 71.9 хувь нь 100 хүртэл толгой малтай ба мянгат малчин 2 өрх байна.

Аймгийн дүнгээр малтай нэг өрхөд 96, малчин нэг өрхөд 133 толгой мал ногдож, өмнөх оноос малчин нэг өрхөд ноогдох малын тоо 26 толгойгоор буурсан байна.

56.7 мянган хээлтэгч мал тоологдсон нь нийт малын 46.4 хувийг эзэлж, өнгөрсөн оноос хээлтэгчийн тоо 6.4 хувь буюу 3.9 мянган толгойгоор буурчээ.

1264 толгой хээлтүүлэгч малын 43.2 хувь нь хуц, ухна байна. Нэг хээлтүүлэгчид 4 ингэ, 9 гүү, 37 үнээ, 78 эм хонь, 80 эм ямаа ногдож, үржлийн нормт хэмжээнээс ингэ, гүү доогуур, эм хонь, эм ямаа ихээхэн дээгүүр, үнээ нормт хэмжээнд ба үүнээс бог малд норм 2.6 дахин их бөгөөд хээлтэгч хээлтүүлэгчийн тохироо алдагдсан байна.

Оны эхний төллөх эх малын 85.9 хувь буюу 52.1 мянган хээлтэгч мал төллөж, гарсан төлийн 95.7 хувь нь бойжиж байна. Өмнөх оноос төллөлт 4.2 пунктээр их, төл бойжилт 3.9 пунктээр бага байна. Нийт гарсан төлийн 4.2 хувь буюу 2222 төл хорогджээ. 100 эхээс бойжуулсан төлийн тоо унага буурч, бусад төрөл дээр өссөн байна.

5396 толгой том мал зүй бусаар хорогдож, мал онд оролт 96.0 хувь, өмнөх оноос 3.6 пунктээр бага байна. Нийт хорогдсон малын 47.4 хувь нь хонь, 32.3 хувь нь ямаа, 15.0 хувь нь үхэр, 5.3 хувь нь адуу байна.

Баян-Өндөр сумын төллөх эх малын 87.4 хувь, Жаргалант сумын төллөх эх малын 85.0 хувь нь төллөж , гарсан төлийн 94.9-96.3 хувь нь бойжиж байна.

Жаргалант суманд 2987 толгой том мал зүй бусаар хорогдсон нь аймгийн нийт хорогдлын 55.4 хувийг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 524 гахай, 1372 шувуу, 11 туулай, 1 илжиг, 336 бүл зөгий тоологдож, өмнөх оноос гахай 16.9 хувиар, зөгий 23 бүл 7.3 хувиар өсч, шувуу 11.8 хувиар багассан байна.

Аймгийн мал эмнэлэгийн байгууллагууд давхардсан тоогоор 100.1 мянган мал, амьтдыг үзлэгт, 165.0 мянган мал амьтдыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд, 407.3 мянган толгой мал амьтдыг паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулжээ. Өмнөх оноос халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан мал амьтад 22.8 хувиар, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан мал амьтад 6.9 хувиар, үзлэг хийсэн мал амьтад 26.3 хувиар буурчээ.

Паразит өвчнөөр 53.6 мянган мал өвчилснөөс 32 нь, халдварт өвчнөөр 27 мал өвчилж хорогдсон байна.

Аймгийн хэмжээнд 252 худаг, 74.1 мян.м.куб багтаамж бүхий 11 усан сан тоологдсоноос 115 худаг нь хувийн аж ахуйнх байна. Тайлант онд 2 худгийг шинээр ашиглалтанд оруулжээ..

Хаврын тариалалтаар 4334.0 га-д үр тариа (үүнээс 4300.0 га-д улаан буудай), 469.2 га-д төмс, 286.8 га-д хүнсний ногоо тариалжээ. Үр тарианы төлөвлөгөөт зорилт 112.9 хувь, төмс 123.5 хувь, хүнсний ногоо 82.4 хувь, малын тэжээл 135.8 хувьтай байна. Тариалалт өмнөх оны мөн үеэс 20.1 хувиар өсчээ. Үр тарианы 53.7 хувь, төмсний 31.6 хувь, хүнсний ногооны 17.2 хувийг гадны аймгийн нутаг дэвсгэрт тариалжээ.

Намрын ургац хураалтаар 4074. га-гаас 6195.6 тн үр тариа, 353.4 га-аас 3005.5 тн төмс, 249 га-аас 2779.1 тн хүнсний ногоо хураан авчээ. Хураасан талбайн 1 га-аас 15.2 цн үр тариа, 85.0 цн төмс, 111.6 цн хүнсний ногоо хураасан байна.

Нийт үр тарианы 58.9 хувь буюу 3653.6 тн, төмсний 59.1 хувь буюу 1777.7 тн, хүнсний ногооны 12.3 хувь буюу 342.1 тн-ыг гадны аймгийн нутаг дэвсгэрт тариалж, хураан авчээ.

Жилийн дүнгээр 8.0 мянган тн хадлан бэлтгэхээс 7.2 мянган тн хадлан бэлтгэж, төлөвлөгөөт зорилт 90.2 хувийн биелэлттэй байна. Баян-өндөр сум 2.5 мянган тн, Жаргалант сум 4.7 мянган тн-ыг бэлтгэжээ. Аймгийн нөөцөнд 250.0 тн өвс бэлтгэсэнээс 100.0 тн-ыг Баян-Өндөр сум, 150.0 тн-ыг Жаргалант сум бэлтгэсэн байна.

Аймгийн дүнгээр 346 иргэнд 25.08 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар, 46 аж ахуйн нэгжид 15.13 га газрыг аж ахуйн бусад зориулалтаар

эзэмшүүлэхээр, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх хуулийн дагуу хүсэлт гаргасан 664 өрхөд 57.2 га газрыг хувьчилж олгожээ.

Газрын төлбөрт 9.2 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөт төлбөр 10.8 хувиар давж биелсэн байна.



Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт 2.1 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, 2.2 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж, өмнөх оноос үйлдвэрлэлт 50.2 хувиар, борлуулалт 48.9 хувиар өсчээ.

Нийт бүтээгдэхүүний 92.5 хувийг уул уурхайн олборлох, 5.8 хувийг боловсруулах, 1.7 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн салбарт үйлдвэрлэжээ.

Нийт бүтээгдэхүүний 99.97 хувь нь Баян-Өндөр суманд, 0.03 хувь Жаргалант суманд үйлдвэрлэгджээ.

Жаргалант сумын үйлдвэрлэлт өмнөх оноос 4.8 хувиар буурсан нь “Поли-Этилен” ХХК-ны үйлдвэрлэлт буурсан нь нөлөөлжээ.

Өмнөх оноос үйлдвэрлэлт цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн салбарт 8.0 хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 5.7 хувиар, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 55.4 хувиар өсчээ.

Боловсруулах салбарын үйлдвэрлэлтийн 48.0 хувийг төмрийн үйлдвэрлэл, 28.7 хувийг ноосон нэхмэлийн үйлдвэрлэл, 11.9 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 4.5 хувийг оёдол, 3.5 хувийг төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл, 1.3 хувийг машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл, 0.9 хувийг резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 0.6 хувийг тавилга үйлдвэрлэл, 0.6 хувийг хэвлэх үйлдвэрлэл, 0.3 хувийг цахилгаан машин хэрэгсэл үйлдвэрлэл, 0.1 хувийг хоёрдогч түүхий эд бэлтгэл эзэлж байна.

Хүнсний бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлтийн 48.7 хувь нь гурил, тэжээлийн, 23.6 хувь нь хүнсний бусад бүтээгдэхүүний, 19.8 хувь нь мах, махан бүтээгдэхүүний, 6.7 хувь нь сүү, сүүн бүтээгдэхүүний, 1.1 хувь нь архи, ундаа, усны үйлдвэрлэлт байна.

“Эрдсүлж” ХХК, “МЦЖ” ХХК-ны үйлдвэрлэлт өссөн нь оёдлын салбарын, “Их-Ар” ХХК-г мэдээнд нэмж хамруулсан нь химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын, “Их тод од” ХХК-ны үйлдвэрлэлт өссөн нь цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын өсөлтөнд, “Ганчагт” ХХК үйл ажиллагаа явуулаагүй, “БСЭХ” ХХК-ны үйлдвэрлэлт буурсан нь машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэлийн салбарын, “Поли-Этилен” ХХК-ны үйлдвэрлэлт буурсан нь хоёрдогч түүхий эд үйлдвэрлэлийн салбарын, “ТЭЁН” ХХК, “Гоё цонх” ХХК, “Мейнспринг” ХХК-ны

үйлдвэрлэлт буурсан, “Бат итгэлт оргил” ХХК үйл ажиллагаа явуулаагүй нь резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын, “Эрдмин” ХХК 2016 онд гол банндаа засвар хийснээр өртөг өндөр тооцогдсон ба 2017 онд өртөг бодитоор тооцогдсон нь төмрийн үйлдвэрлэлтийн бууралтанд нөлөөлжээ.

Гол нэр төрлийн 58 бүтээгдэхүүнийг судалгаанд хамруулснаас II гурил, дулаан эрчим хүч, дээд гурил, бетон зуурмаг, дайвар бүтээгдэхүүн, хүчилтөрөгч, хийжүүлсэн цэвэр ус, цахилгаан эрчим хүч, ямааны мах, хулдаасан хэвлэл, молибдений баяжмал, хивс, хүүхдийн савхин гутал, хиам, монгол эм, шавардлагын зуурмаг, буриад гутал, нарийн боов, хүснэгт маягт, бусад хэвлэмэл зүйлс, гоймон, бялуу, ажлын хувцас, хонины мах, эсгий, гудас матрас, лед чийдэн, талх, амтат ус ундаа, ноолууран алчуур, төмөр бетон эдлэл, вакуум хаалга цонх 1.4-99.5 хувиар, сонин, зайрмаг, ган төмөр хийц, ноосон хөнжил, оёмол хөнжил, ном, хэвийн боов 2.3-9.3 дахин өсч, бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 2.4-87.5 хувиар буурсаны дотор пивоны үйлдвэрлэл 87.5 хувиар буурчээ.

Аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын тоо 0.6 хувиар, хөдөлмөрийн бүтээмж 49.2 хувиар өсчээ.

Энэ онд даршилсан ногоо үйлдвэрлэлийн “Эрдэнэт газрын өгөөж” ХХК, хэрчсэн гурил үйлдвэрлэлийн “Их хүрхрэн ундрага” ХХК, талх нарийн боов үйлдвэрлэлийн “Билгүүн өглөө” ХХК, “Их гэрэлт зам” ХХК, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн “Орхон хаан сүлжмэл” ХХК, “Итгэл аврагч” ХХК, оёдолын “Уран хатан мандал” ХХК, “Баянбэх” ХХК, модон эдлэл үйлдвэрлэлийн “Бат билэгт буян” ХХК, хэвлэлийн “Мэргэн гүүш” ХХК, “Мээж” ХХК, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн “Их-Ар” ХХК, хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн “Бидэрт манхан” ХХК, “Нөмрөг вэртекс” ХХК, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэлийн “Одон трейд” ХХК, “Их мичид” ХХК, “Хаадын цадиг” ХХК, “Мөнх тэнгэрийн ташуур” ХХК, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн “Нившээл” ХХК, “Угтаал тод пүүс” бууз банш үйлдвэрлэлийн 1, модон эдлэлийн 1 иргэн зэрэг 21 нэгжийн мэдээллийг шинээр статистикт нэмж хамрууллаа.



Тээвэр холбоо

Тээврийн байгууллагууд 153.7 мян.тн ачаа тээвэрлэн, 51.2 сая.тн/км-ийн ачаа эргэлт, 4.9 сая зорчигч тээвэрлэн, 101.2 сая.хүн/км-ийн зорчигч эргэлт хийж, тээврийн үйлчилгээнээс 17.9 тэрбум төгрөгийн орлоготой ажиллажээ. Өмнөх оноос тээврийн орлого 21.2 хувь, тээсэн ачаа 9.0 хувь, зорчигч эргэлт 0.3 хувиар буурсан байна. Зорчигч тээврийн үйлчилгээнд 70 автобус, 27 микроавтобус, 503 такси гарч тэдгээрт 878 хүн ажиллаж, өмнөх оноос автобус, тээврийн үйлчилгээнд ажиллаж буй ажилчдын тоо өсч, микроавтобус, таксины тоо хасагджээ.

Төмөр замын тээврээр 744.5 мян.тн ачаа тээвэрлэн, 710.2 сая.тн/км-ийн ачаа эргэлт хийж, 118.2 мянган зорчигч тээвэрлэн, 56.2 сая хүн.км-ийн зорчигч эргэлт гүйцэтгэжээ. Өмнөх оноос тус тээврээр оруулсан цагаан будаа, элсэн чихэр, гурил 4.2-81.6 хувиар өсч, хүнсний ногоо, ургамалын тос, барилгын материал 5.5-26.3 хувиар буурчээ. Гаргасан хаягдал төмөр, молибдени, катодын зэс, үр тариа, зүсмэл, зэс, гурил 4.7-66.7 хувиар буурсан байна.

Жилийн туршид авто техникийн улсын үзлэгт 15.8 мянган автомашин хамрагдсанаас 77.8 хувь нь суудлын машин, 18.6 хувь нь ачааны машин ба нийт техник хэрэгслийн 91.0 хувь нь иргэдийн хувийн автомашин байна. Үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслийн тоо өмнөх оноос 5.4 хувиар өсчээ.

Холбооны байгууллагууд 6.4 тэрбум төгрөгийн тарифын орлоготой ажилласны 91.7 хувийг хүн амаас орсон орлого эзэлж байна. Өмнөх оноос нийт орлого 16.3 хувиар буюу 1.3 тэрбум төгрөгөөр буурчээ. Аймгийн хэмжээнд үүрэн телефон хэрэглэгчдийн тоо 240.7 мянгад хүрч, өмнөх оноос 11.7 хувь буюу 25.2 мянган хэрэглэгч нэмэгдсэн. Мэдээлэл харилцаа холбооны бүх орлогын 60.6 хувь нь үүрэн телефоны орлого байна.

Интернетийн үйлчилгээний 9 цэг давхардсан тоогоор 26.6 мянган хүнд үйлчилж, 23.3 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Өмнөх оноос орлого 54.5 хувиар буурсан байна. Аймгийн хэмжээнд интернетийн байнгын хэрэглэгч 6.6 мянга болж, өмнөх оноос 2.6 хувиар өссөн байна.



Худалдаа үйлчилгээ

Аймгийн худалдаа нийтийн хоолны 742 цэг салбар 114.1 тэрбум төгрөгийн бараа гүйлгээ хийж, бараа гүйлгээний нийт хэмжээ өмнөх оноос 9.1 хувиар өссөн байна.

Нийт бараа гүйлгээний 36.6 хувийг хүнсний дэлгүүр, 29.6 хувийг шатахуун борлуулалт, 17.1 хувийг зоогийн газар, 8.4 хувийг барааны дэлгүүр, 4.6 хувийг эм борлуулалтын орлого, 1.9 хувийг барилгын материалын дэлгүүрийн орлого, 1.2 хувийг авто сэлбэгийн дэлгүүрийн орлого, 0.3 хувийг контейнерийн орлого, 0.3 хувийг авто засварын газрын орлого эзэлж байна.

Өмнөх оноос хүнсний дэлгүүрийн орлого 0.3 хувиар, барааны дэлгүүрийн орлого 3.7 хувиар, авто засварын газрын орлого 18.2 хувиар, шатахуун борлуулалтын орлого 19.2 хувиар, зоогийн газрын орлого 21.8 хувиар, барилгын материалын дэлгүүрийн орлого 66.7 хувиар, авто сэлбэгийн дэлгүүрийн орлого 68.8 хувиар нэмэгдэж, эм борлуулалтын орлого 9.1 хувиар, ТҮЦ-ний орлого 14.5 хувиар, контейнерийн орлого 73.4 хувиар, буурчээ. Нийт бараа гүйлгээний 99.2 хувь нь Баян-Өндөр суманд хийгджээ.



Барилга, орон сууц, нийтийн аж ахуй

Их барилгын 127 аж ахуйн нэгж, 37 бүлгэм 58.1 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг 271 объектод хийж гүйцэтгэсний 37.7 хувь буюу 21.9 тэрбум төгрөг нь их засварын ажил байна. Гүйцэтгэсэн ажлын дүн өмнөх оноос 14.1 хувиар багасчээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 249 объектод 23.6 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсэн нь өмнөх оноос 22.5 хувиар, улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажил 16.8 хувиар нэмэгдсэн байна.

Тайлант онд аймгийн дүнгээр 3.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 25 объектийг ашиглалтад оруулсан нь өмнөх оноос 77.3 хувиар бага байна.

Тайлант онд 14.7 мянган кв.м талбай бүхий нийтийн зориулалттай 107 айлын орон сууц, 1.9 мянган кв.м талбай бүхий 30 айлын хувийн байшин ашиглалтанд орж, эдгээрт 443 хүн амьдарч байна. Ашиглалтанд орсон нийтийн зориулалттай орон сууцны тоо өмнөх оныхоос 13.7 хувиар буурч, сууцны тусдаа байшин буюу хувийн байшин өмнөх оныхоос 52.6 хувиар өссөн байна.

Нийтийн аж ахуйн болон ахуйн үйлчилгээ

Нийтийн аж ахуйн үйлчилгээний орлого 16.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 2.0 хувиар өссөн байна. Нийт орлогын 46.2 хувийг орон сууцны, 41.4 хувийг аж ахуйн нэгж албан газрын, 6.5 хувийг зочид буудлын, 3.4 хувийг хог тээвэрлэлтийн, 1.5 хувийг зөөврийн цэвэр ус борлуулалтын, 1.0 хувийг халуун ус, засвар үйлчилгээ, саун үйлчилгээний орлого бүрдүүлж байна.

Өмнөх оноос аж ахуйн нэгж, албан газрын орлого, орон сууц, хог тээвэрлэлт, халуун усны орлого 2.1% - 38.2% нэмэгдэн, зочид буудал, саун, зөөврийн цэвэр ус борлуулалт, засвар үйлчилгээ, иргэдийн үйлчилгээний орлого 18.8 - 90.0 хувиар буурсан байна. Иргэдийн үйлчилгээний орлого буурсан нь орлого төвлөрүүлэхээ больсонтой холбоотой.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний орлогын 99.8 хувийг Баян-Өндөр сум эзэлж байна.

Ахуйн үйлчилгээний салбарын дүнгээр 1.7 тэрбум төгрөгийн үйлчилгээ явуулж, орлого өмнөх оноос 3.4 хувиар бага байна.

Нийт орлогын 50.3 хувийг барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ, 32.8 хувийг үсчин, 6.5 хувийг прокат ба тоглоомын цэгийн, 3.9 хувийг гутал засвар, 3.5 хувийг гэрэл зураг, 2.3 хувийг хими цэвэрлэгээ, 0.5 хувийг телевизор засвар, 0.2 хувийг цаг засварын орлого эзэлж байна.

Ахуйн үйлчилгээний орлогын 99.8 хувийг Баян-Өндөр сум бүрдүүлдэг ба Жаргалант суманд зөвхөн 1 үсчин үйл ажиллагаа явуулж байна.

31 сууц өмчлөгчдийн холбоод 1283.7 сая төгрөгийн орлого, 1233.4 сая төгрөгийн зарлагатай ажиллажээ. Өмнөх оноос орлого 11.6 хувиар, зарлага 9.1 хувиар нэмэгджээ.

Барилгын засвар үйлчилгээний зардалд 347.2 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оноос 40.9 хувиар нэмэгдсэн байна. Нийт зардлын 28.1 хувийг барилгын засвар үйлчилгээнд зарцуулжээ.

Аймгийн зоогийн газрын 139 цэг салбар 19.5 тэрбум төгрөгийн бараа гүйлгээ хийсэн нь өмнөх оноос 21.8 хувиар өсч, ресторан, баарны орлого 31.9 хувиар нэмэгдсэн байна. Нийтийн хоолны бараа гүйлгээний 36.7 хувийг ресторан, баарны орлого эзэлж байна.



Бүртгэл, хяналт шалгалт

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр энэ онд 310 аж ахуйн нэгж, байгууллага нэмэгдэн, 44 аж ахуйн нэгж хасагдсанаар (татан буугдсан, шилжсэн) аж ахуйн нэгж, байгууллагын тоо 4536 болж, өмнөх оноос 6.2 хувиар буюу 266-аар нэмэгджээ.

Статистикийн бизнес регистрийн санд 4409 аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагаас 2308 буюу 52.3 хувь нь үйл ажиллагаа явуулж байгаа, 19.0 хувь нь үйл ажиллагаа эхлээгүй, 24.9 хувь нь түр зогссон, 2.1 хувь нь бүрэн зогссон байна.

Бизнес регистрийн санд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын 73.8 хувь нь ХХК, 16.2 хувь нь төрийн бус байгууллага, 4.2 хувь нь төсөвт байгууллага, 3.0 хувь нь зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл, 1.1 хувь нь хоршоо, 0.9 хувь нь бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл байна.

АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

II НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ




ӨРХ, ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

НИЙТ ХҮН АМ, ӨРХ

Үзүүлэлт	2016	2017	2017/2016=%
Нийт хүн ам*	101891	103625	101.7
Гадаадад оршин суугаа	1816	2002	110.2
Үүнээс: Орхон аймагт амьдардаггүй	6403	6391	99.8
Байнга оршин суудаг	93672	95232	101.7
Гадаадын харъяат	755	588	77.9
бүгдээс: эрэгтэй	49954	50819	101.7
хүйсээр эмэгтэй	51937	52833	101.7
бүгдээс: Баян-Өндөр сум	98050	99758	101.7
сумаар Жаргалант сум	3841	3867	100.7
0-15 насны	30051	31020	103.2
бүгдээс: 16-59 насны	65777	66178	100.6
насны бүлгээр үүнээс: 16-34 насны	34024	33824	99.4
60 ба түүнээс дээш насны	6063	6454	106.4
Нийт өрхийн тоо	28190	28704	101.8
бүгдээс: Баян-Өндөр сум	27045	27533	101.8
сумаар Жаргалант сум	1145	1171	102.3
Нэг өрхөд ногдох хүний тоо, аймгийн дүн	3.6144	3.6101	100.0

Тайлбар: *-Хүн ам, өрхийн мэдээллийн цахим санд бүртгэлтэй Орхон аймгийн харъяат иргэдийн тоогоор нийт хүн амын тоо гарсан.

Хүн амын тоо



СУУРИН АМЫН ТОО, насны бүлгээр, сумаар

	2016	2017	үүнээс: сумаар	
			Баян-Өндөр	Жаргалант
Хүн амын тоо*	100075	101652	97814	3838
0-1	4502	4523	4366	157
2-5	9520	9609	9301	308
6-15	15823	16614	16000	614
16-17	3074	2941	2819	122
18	1471	1535	1474	61
19-34	28485	28168	27180	988
35-54	26815	26849	25801	1048
55-59	4344	4964	4752	212
60-69	3728	4088	3876	212
70-79	1672	1692	1601	91
80-89	568	593	569	24
90-99	72	75	74	1
100 дээш	1	1	1	0

Тайлбар: * Гадаадын иргэд, гадаадад оршин суугаа Орхон аймгийн харъяат иргэд ороогүй болно.

СУУРИН ХҮН АМЫН ТОО, хүйсээр, багаар

2017 оны жилийн эцсийн байдлаар

	Өрхийн тоо	Хүн амын тоо	Дүнд эзлэх хувь	бүгдээс:		Эмэгтэйчүүдийн эзлэх хувь
				эрэгтэй	эмэгтэй	
Баян-Өндөр сум - бүгд	27533	97814	100.0	47864	49950	51.1
Зэст	1391	4640	4.7	2174	2466	53.1
Оюут	1499	5381	5.5	2627	2754	51.2
Уурхайчин	1545	5628	5.8	2649	2979	52.9
Хүрэнбулаг	1487	5321	5.4	2556	2765	52.0
Уртбулаг	1353	4761	4.9	2282	2479	52.1
Согоот	1454	5302	5.4	2522	2780	52.4
Дэнж	1545	5619	5.7	2784	2835	50.5
Бүрэнбүст	1129	4182	4.3	1997	2185	52.2
Шанд	739	2593	2.7	1316	1277	49.2
Наран	1108	3952	4.0	1980	1972	49.9
Цагаанчулуут	1424	5018	5.1	2478	2540	50.6
Булаг	925	3341	3.4	1611	1730	51.8
Баянцагаан	1580	5612	5.7	2755	2857	50.9
Говил	985	3684	3.8	1851	1833	49.8
Рашаант	1261	4714	4.8	2333	2381	50.5
Эрдэнэ	2034	7131	7.3	3466	3665	51.4
Баянбулаг	1013	3417	3.5	1693	1724	50.5
Их залуу	1203	4308	4.4	2187	2121	49.2
Даваат	1234	4350	4.4	2160	2190	50.3
Яргуйт	1738	5810	5.9	2887	2923	50.3
Уртын гол	886	3050	3.1	1556	1494	49.0
Жаргалант сум - бүгд	1171	3838	100.0	2017	1821	47.4
Улаантолгой	310	1075	28.0	557	518	48.2
Жаргалант	351	1272	33.1	642	630	49.5
Дулаан-Уул	510	1491	38.8	818	673	45.1
Аймгийн дүн	28704	101652	x	49881	51771	50.9

ӨРХ, ХҮН АМЫН ТОО, багаар

	Өрхийн тоо		Хүн амын тоо*	
	2016	2017	2016	2017
Баян-Өндөр сум - бүгд	27045	27533	96259	97814
Зэст	1325	1391	4239	4640
Оюут	1476	1499	5401	5381
Уурхайчин	1517	1545	5522	5628
Хүрэнбулаг	1451	1487	5133	5321
Уртбулаг	1294	1353	4550	4761
Согоот	1407	1454	5155	5302
Дэнж	1571	1545	5806	5619
Бүрэнбүст	1087	1129	4060	4182
Шанд	724	739	2503	2593
Наран	1105	1108	4044	3952
багаар Цагаанчулуут	1340	1424	4788	5018
Булаг	941	925	3384	3341
Баянцагаан	1620	1580	5607	5612
Говил	992	985	3672	3684
Рашаант	1280	1261	4825	4714
Эрдэнэ	1921	2034	6749	7131
Баянбулаг	976	1013	3346	3417
Их залуу	1187	1203	4203	4308
Даваат	1238	1234	4435	4350
Яргуйт	1716	1738	5787	5810
Уртын гол	877	886	3050	3050
Жаргалант сум - бүгд	1145	1171	3816	3838
багаар Улаантолгой	296	310	1053	1075
Жаргалант	344	351	1296	1272
Дулаан-Уул	505	510	1467	1491
Аймгийн дүн	28190	28704	100075	101652

Тайлбар: *-Суурин хүн амаар гаргав.

ХҮҮХЭД БА ГЭР БҮЛ

ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮҮХЭД

	2016	2017	2017/2016=%
Бүтэн өнчин хүүхдийн тоо	135	125	92.6
Хагас өнчин хүүхдийн тоо	1040	1009	97.0

ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭМЭГТЭЙЧҮҮД

	2016	2017	2017/2016=%
Өрх толгойлсон эмэгтэйчүүд	2997	3021	100.8
3 хүртэлх	1645	1677	101.9
Үүнээс: гишүүдийн тоогоор 3-5	1061	1067	100.6
6, түүнээс дээш	291	277	95.2

18 ХҮРТЛЭХ НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН ХҮНИЙ ТОО

	2016	2017	2017/2016=%
Хүүхэдтэй гэр бүлгүй - бүгд	1773	1771	99.9
Үүнээс: ~эхийн тоо	1601	1619	101.1
~эцгийн тоо	172	152	88.4

ХҮН АМ, НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, сумаар

	Баян-Өндөр сум		2017/2016=%	Жаргалант сум		2017/2016=%
	2016	2017		2016	2017	
Бүтэн өнчин хүүхэд	132	122	92.4	3	3	100.0
Хагас өнчин хүүхэд	989	966	97.7	51	43	84.3
Өрх толгойлсон эмэгтэй	2869	2891	100.8	128	130	101.6
18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх	1569	1593	101.5	32	26	81.3
Хөгжлийн бэрхшээлтэй хүн	3864	3913	101.3	194	202	104.1

ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, бүсийн аймгуудаар

	2016	2017
БҮТЭН ӨНЧИН ХҮҮХЭД		
Бүгд	683	652
Архангай	121	116
Баянхонгор	111	91
Булган	37	34
Орхон	135	125
Өвөрхангай	108	105
Хөвсгөл	171	181
ХАГАС ӨНЧИН ХҮҮХЭД		
Бүгд	8293	8035
Архангай	1730	1756
Баянхонгор	1535	1185
Булган	586	626
Орхон	1040	1009
Өвөрхангай	1638	1668
Хөвсгөл	1764	1791

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН

ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТ, ҮРЧЛЭЛТ

	2016	2017	2017/2016=%
Төрсөн хүүхэд - бүгд	2345	2388	101.8
Үүнээс: ~эрэгтэй	1220	1231	100.9
~эмэгтэй	1125	1157	102.8
Нас баралт - бүгд	524	537	102.5
Үүнээс: ~эрэгтэй	307	351	114.3
~эмэгтэй	217	186	85.7
Бүгдээс: ~нялхас	8	5	62.5
Эзлэх хувь ~нялхас	1.5	0.9	-0.6
Гэрлэлт	563	652	115.8
Цуцлалт	177	161	91.0
Үрчлэлт	49	66	134.7

ЕРӨНХИЙ КОЭФФИЦИЕНТУУД*

	2016	2017	2017/2016=%
Төрөлт	23.0	23.0	0.0
Нас баралт	5.1	5.2	0.1
Цэвэр өсөлт	17.9	17.9	0.0
Гэрлэлт	20.0	22.7	2.7
Цуцлалт	6.3	5.6	-0.7

Тайлбар: * - 1000 хүн (өрх)-д ногдох үзүүлэлт

ЦУЦЛАЛТ, гэр бүлээр

	2016	2017	2017/2016=%
БҮГД	177	161	91.0
Гэр бүл байсан хугацаагаар (жилээр)			
1 хүртэл	2	10	5.0 ²
1-3	12	7	58.3
4-6	12	12	100.0
7-9	48	25	52.1
10-14	44	54	122.7
15-19	25	18	72.0
20 ба дээш	34	35	102.9

Тайлбар: ²-Дахин их

ҮРЧЛЭЛТ, хүүхдийн тоогоор

	2016	2017	2017/2016=%
БҮГД	49	66	134.7
3 хүртэл насны	27	31	114.8
Үүнээс: 3-6 насны	13	10	76.9
7-9 насны	1	6	6.0 ²
10 ба дээш насны	8	19	2.4 ²

Тайлбар: ²-Дахин их

1000 ХҮНД НОГДОХ ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ЦЭВЭР ӨСӨЛТ, бүсийн аймгуудаар

	Төрөлт		Нас баралт		Цэвэр өсөлт	
	2016	2017	2016	2017	2016	2017
Архангай	24.0	23.7	6.4	5.7	17.7	18.0
Баянхонгор	24.2	24.3	6.7	5.6	17.6	18.6
Булган	21.7	21.0	6.2	6.2	15.4	14.8
Орхон	23.5	22.6	5.3	5.5	18.2	17.1
Өвөрхангай	25.1	22.4	6.8	6.3	18.4	16.1
Хөвсгөл	24.2	22.4	6.7	6.5	17.5	15.9
Улсын дүн	25.9	23.9	5.8	5.5	20.1	18.4

ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС

	2016	2017*
Архангай	0.659	0.656
Баянхонгор	0.651	0.649
Булган	0.667	0.665
Орхон	0.759	0.778
Өвөрхангай	0.637	0.638
Хөвсгөл	0.633	0.631
Бүсийн дүн	0.673	0.680
Улсын дүн	0.733	0.734

ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ

	2016	2017
Архангай	70.77	70.81
Баянхонгор	69.12	69.27
Булган	73.17	73.40
Орхон	71.07	71.33
Өвөрхангай	69.55	69.85
Хөвсгөл	66.01	66.18
Улсын дүн	69.57	69.89

Тайлбар:* -Урьдчилсан дүн

Аймгийн УБХ-ийн мэдээгээр

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН, сумаар

	Баян-Өндөр сум		2017/2016=%	Жаргалант сум		2017/2016=%
	2016	2016		2016	2016	
Төрсөн хүүхэд - бүгд	2273	2312	101.7	72	76	105.6
~эрэгтэй	1180	1191	100.9	40	40	100.0
Үүнээс:						
~эмэгтэй	1093	1121	102.6	32	36	112.5
Нас баралт - бүгд	501	519	103.6	23	18	78.3
~эрэгтэй	293	335	114.3	14	16	114.3
Үүнээс:						
~эмэгтэй	208	184	88.5	9	2	22.2
Бүгдээс: ~нялхас	8	5	62.5	-	-	-
Эзлэх хувь ~нялхас	1.6	1.0	-0.6	-	-	-
Гэрлэлт	539	635	117.8	24	17	70.8
Цуцлалт	175	155	88.6	2	6	3.0 ²
Үрчлэлт	43	60	139.5	6	6	100.0

Тайлбар: ²-Дахин их

Аймгийн УБХ-ийн мэдээгээр

БҮРТГҮҮЛСЭН ГЭР БҮЛ, хугацаагаар

	2016	2017	2017/2016=%
Бүртгүүлсэн гэр бүлийн тоо	563	652	115.8
<i>тайлант онд гэр бүл болсон</i>	67	203	3.0 ²
Үүнээс: <i>тайлант оноос өмнө гэр бүл болсон</i>	496	449	90.5
~жилийн өмнө	116	65	56.0
Үүнээс: ~2-3 жилийн өмнө	142	118	83.1
~4 ба түүнээс дээш жилийн өмнө	238	266	111.8

ГЭР БҮЛЭЭ БҮРТГҮҮЛСЭН ХҮНИЙ ТОО, нас, хүйсээр

	ЭРЭГТЭЙ		ЭМЭГТЭЙ	
	2016	2017	2016	2017
БҮГД	563	652	563	652
18-19 насны	25	5	23	6
20-24 насны	120	134	141	183
25-29 насны	221	281	230	266
30-34 насны	105	116	88	81
35-39 насны	30	39	33	52
40-44 насны	30	24	22	29
45-49 насны	14	28	10	18
50 ба дээш насны	18	25	16	17

ГЭР БҮЛЭЭ БҮРТГҮҮЛСЭН ХҮНИЙ ТОО, бүтцээр

	ЭРЭГТЭЙ		ЭМЭГТЭЙ	
	2016	2017	2016	2017
БҮГД	100.0	100.0	100.0	100.0
18-19 насны	4.4	0.8	4.1	0.9
20-24 насны	21.3	20.6	25.0	28.1
25-29 насны	39.3	43.1	40.9	40.8
30-34 насны	18.7	17.8	15.6	12.4
35-39 насны	5.3	6.0	5.9	8.0
40-44 насны	5.3	3.7	3.9	4.4
45-49 насны	2.5	4.3	1.8	2.8
50 ба дээш насны	3.2	3.8	2.8	2.6

Аймгийн УБХ-ийн мэдээгээр

ТӨРСӨН ЭХЧҮҮД (боловсролоор, гэр бүлийн байдлаар)

	2016	2017	2017/2016=%
1. Төрсөн эхчүүд	2324	2361	101.6
~ дээд	1170	1285	109.8
үүнээс: ~ тусгай, тех мэргэжлийн	36	40	111.1
боловсро- ~ бүрэн дунд	1007	968	96.1
лоор ~ суурь	89	52	58.4
~ бага	15	12	80.0
~ боловсролгүй	7	4	57.1
Гэр бүлийн Гэр бүлгүй	303	248	81.8
байдал Гэр бүлтэй	2021	2113	104.6
үүнээс: ~ баталгаатай	1216	1218	100.2
2. Төрсөн хүүхэд - бүгд	2345	2388	101.8
15 хүртэлх	1	-	
15 - 19	67	62	92.5
үүнээс: 20 - 24	638	556	87.1
эхийн насаар 25 - 29	737	762	103.4
30 - 34	527	593	112.5
35 - 39	302	335	110.9
40 - 44	70	77	110.0
45 - 49	3	3	100.0

ХҮН АМЫН МЕХАНИК ХӨДӨЛГӨӨН



ШИЛЖИН ЯВАГСАД

Үзүүлэлт	2016	2017	2017/2016=%
Хүний тоо	2989	1944	65.0
үүнээс: 0-14 насны	670	506	75.5
насаар 15-54	2109	1298	61.5
55 ба түүнээс дээш насны	210	140	66.7
Бүгдээс: Улаанбаатар	1474	611	41.5
аймгаар Дархан -уул	112	118	105.4
Булган	308	408	132.5
Сэлэнгэ	93	153	164.5
Хөвсгөл	81	129	159.3

ШИЛЖИН ИРЭГСЭД

Үзүүлэлт	2016	2017	2017/2016=%
Хүний тоо	2202	2359	107.1
үүнээс: 0-14 насны	596	675	113.3
насаар 15-54	1428	1500	105.0
55 ба түүнээс дээш насны	178	184	103.4
Бүгдээс: Улаанбаатар	875	863	98.6
аймгаар Булган	455	533	117.1
Завхан	76	104	136.8
Увс	42	35	83.3
Хөвсгөл	129	116	89.9
Архангай	101	105	104.0


ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БҮТЭЦ



АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЗАХ ЗЭЭЛ, мянган хүнээр

	2016	2017
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	42.7	42.1
Ажиллагчдын тоо	33.1	32.2
Ажилгүй иргэдийн тоо	9.6	9.9
Ажилгүйдлийн түвшин (%)	22.4	23.5
Эдийн засгийн идэвхгүй хүн ам	23.8	23.5

Тайлбар: Ажиллах хүчний түүвэр судалгааны дүнгээр тооцов.



	2016	2017
Эдийн засгийн идээхтэй хүн ам		
Бүсийн дүн	274.6	282.7
Архангай	44.6	45.2
Баянхонгор	45.1	43.3
Булган	28.2	30.8
Орхон	42.7	42.1
Өвөрхангай	54.4	59.7
Хөвсгөл	59.6	61.6
Ажиллагчдын тоо		
Бүсийн дүн	245.6	254.9
Архангай	42.4	42.8
Баянхонгор	40.0	40.9
Булган	25.9	27.5
Орхон	33.1	32.2
Өвөрхангай	49.6	55.2
Хөвсгөл	54.6	56.3
Ажилгүй иргэдийн тоо		
Бүсийн дүн	29.0	27.8
Архангай	2.2	2.4
Баянхонгор	5.1	2.4
Булган	2.3	3.3
Орхон	9.6	9.9
Өвөрхангай	4.8	4.5
Хөвсгөл	5.0	5.3
Ажилгүйдлийн түвшин		
Бүсийн дүн	10.6	9.8
Архангай	5.0	5.4
Баянхонгор	11.2	5.6
Булган	8.2	10.7
Орхон	22.4	23.5
Өвөрхангай	8.9	7.6
Хөвсгөл	8.5	8.5
Эдийн засгийн идэвхгүй хүн ам		
Бүсийн дүн	114.5	117.0
Архангай	14.1	14.7
Баянхонгор	17.8	23.3
Булган	10.8	9.8
Орхон	23.8	23.5
Өвөрхангай	17.7	17.7
Хөвсгөл	30.3	28.0

Тайлбар: Ажиллах хүчний түүвэр судалгааны дүнгээр тооцов.


ОРХОН АЙМГИЙН АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, эдийн засгийн зарим салбараар

Эдийн засгийн салбараар	2016		2017	
	Бүгд	үүнээс: эмэгтэй	Бүгд	үүнээс: эмэгтэй
